

SMITTSKYDDSBLAD

Patientinformation

MRSA

Översättning till mongoliska

Version 2023-04-18

MRSA, өвчтөний мэдээлэл

Би яагаад энэ мэдээллийг авсан бэ?

Шинжилгээгээр танд антибиотикт тэсвэртэй MRSA гэгддэг нян байгааг тогтоосон. Энэ юу болох тухай мөн бусдад халдварлуулахгүйн тулд юу анхаарах хэрэгтэйг та энэ мэдээллийн хуудаснаас уншиж болно.

MRSA гэж юу вэ?

MRSA нь метициллинд тэсвэртэй алтлаг стафилококк буюу зарим антибиотикт тэсвэртэй болсон стафилококк бактерийн нэг хувилбар юм.

MRSA өвчний шинж тэмдэг өгөхгүйгээр арьс, салст бүрхэвчид байдаг тул тийм хүнийг тээгч гэнэ. Ердийн стафилококкийн нэгэн адил MRSA нь жишээлбэл шархны халдвар үүсгэж болно.

MRSA хэдийгээр энгийн стафилококкоос илүү эсвэл ноцтой халдвар үүсгэдэггүй ч, халдварыг эмчлэхэд тусгай төрлийн антибиотик хэрэглэх шаардлагатай болдог.

MRSA хэрхэн халдварлах вэ?

MRSA нь хүмүүсийн хооронд голчлон арьсаар, тухайлбал гараар дамжин халдварлана. Бактери нь биеийн тамирын хэрэгсэл гэх мэт хүрээлэн буй орчны зүйлд наалдаж, тэндээсээ цааш тархдаг.

MRSA халдвараар өвчлөөгүй зөвхөн тээгч хүн бусдад халдварлах нь ховор. Гэхдээ зарим тохиолдолд бактерийн хэмжээ нэмэгдэж, халдвар тархах эрсдэл нэмэгддэг. Үүнийг халдвар тархах эрсдэлт хүчин зүйл гэнэ.

Халдвар тархах эрсдэлт хүчин зүйл нь дараах байж болно:

- Халдвартай шарх, буглаа эсвэл импетиго (гахайн цэцэг) гэх мэт арьсны халдвар
- Ил шарх
- Хүндэрсэн эсвэл нойтон экзем / чихний сувгийн экзем
- Арьсны зарим архаг өвчин
- биенд оруулсан нүх, гуурс (катетер).

MRSA-аас эмчлэгдэх боломжтой юу?

MRSA ихэвчлэн өөрөө алга болдог. Үүнд хэдэн сараас хэдэн жил хүртэл хугацаа шаардагдаж болно. Бактери арилсанг мэдэхийн тулд давтан шинжилгээ өгөх хэрэгтэй. Доор дурьдсан хяналт, баримтлах дүрмийг цаашид шаардлагагүйг зөвхөн MRSA-г хариуцсан эмч шийднэ. Дор хаяж гурван сарын хугацаанд хоёр дараалсан шинжилгээнд MRSA илрээгүй тохиолдолд хяналтыг зогсоож болно.

Бусдад халдварлахгүйн тулд юуг анхаарах ёстой вэ?

Таны хийж чадах хамгийн чухал зүйл бол гарын ариун цэврийг сайтар сахих явдал. Танд эрсдэлт хүчин зүйл байхгүй бол та ердийнхөөрөө амьдрах боломжтой бөгөөд халдвар тараах эрсдэл бага.

Хүүхэд цэцэрлэг, сургуульдаа явж бүх үйл ажиллагаанд нь оролцох боломжтой. Хүүхдээ MRSA тээгч болохыг асран хамгаалагч нь цэцэрлэг, сургуульд нь мэдэгдэх шаардлагагүй. Цэцэрлэгийн хүүхэд зарим тохиолдолд гэртээ үлдэх шаардлагатай болдог тул доорх баримтлах дүрмийг харна уу.

Хэрэв та амьтантай ажилладаг бол тусгай зөвлөгөө авах магадлалтай. Энэ тохиолдолд таны эмч халдвар хамгааллын эмчтэй зөвлөлдөнө.

Баримтлах дүрэм

MRSA нь Халдвар хамгааллын хуулийн дагуу нийтэд аюултай өвчин. Тиймд та эмчийн өгөх баримтлах дүрэм гэгдэх зарим дүрмийг дагах ёстой.

- Хэрэв танд халдвар тархах эрсдэлт хүчин зүйл бий бол доор дурдсан эрүүл ахуйн тусгай журмыг дагах ёстой.
- Хэрэв танд арьсны халдвар, ил шарх, нойтон экзем бий бол бие махбодийн их контакттай спортоор хичээллэхгүй байх, нийтийн биеийн тамирын заал гүм ашиглахгүй байх ёстой.
- Цэцэрлэгийн хүүхэд халдвартай шарх, импетиго (гахайн цэцэг) эсвэл хүндэрсэн, нойтон экземтэй бол гэртээ үлдэх ёстой.
- Хэрэв та арьсны халдвар, ил шарх эсвэл нойтон экземтэй бол арьс цоолох, шивээс хийлгэх эсвэл массаж, эмнэлгийн бус хөлийн эмчилгээ гэх мэт арьс, салслагийн эмчилгээнд орвол MRSA халдвар тээгч гэдгээ хэлэх ёстой.
- Эмнэлгийн тусламж, шүдний эмчилгээ, эмнэлгийн хөлийн эмчилгээ авахдаа MRSA халдвар тээгч гэдгээ мөн хэлэх ёстой. Энэ гэртээ эсвэл халамжийн газар эмчилгээ асаргаа хийлгэхийн аль алинд нь хамаарна. Хэрэв та худалдан авалт хийх, цэвэрлэгээ хийх, эмээ хуваарилах, салхинд алхах зэрэгт тусламж үйлчилгээ авдаг бол MRSA халдвар тээгч гэдгээ хэлэх шаардлагагүй.
- Хэрэв эмч таныг халдвар тархах эрсдэлт хүчин зүйлтэй гэж үзвэл, эрүүл мэнд асаргааны байгууллагад ажиллаж суралцаж байгаа та эмчилгээний ажилд оролцож болохгүй.
- Та эмчтэйгээ холбоотой байж, шаардлагатай шинжилгээг хийлгэх ёстой.

Хэрэв та өөрт өгсөн баримтлах дүрмийг буруу гэж үзэж буй бол бүс нутгийн халдвар хамгааллын эмчтэй холбогдож болно.

Эрсдэлт хүчин зүйлтэй танд зориулсан эрүүл ахуйн тусгай зөвлөмж

Танд эрсдэлт хүчин зүйл бий бол халдвар тараах эрсдэл нэмэгдэнэ. Тиймд дараахийг анхаарах хэрэгтэй.

- Гараа сайтар угаа. Өөрийн алчуур, ариун цэврийн хэрэгсэл хэрэглэ.
- Бусадтай хамт усан бассейнд сэлж болохгүй.
- Шархыг боолтоор хааж, шингэн шүүрч байвал боолтыг соль.
- Хэрэв та катетертэй бол хувцасныхаа дотор зүү.
- Шарх, боолт, катетерт хүрснийхээ дараа гараа угаа.

Халдвар мөрдөлт

Халдвар хамгааллын хуулийн дагуу та халдвар мөрдөх ажилд оролцох ёстой. Энэ нь та эрүүл мэндийн ажилтанд хэзээ, хаана, хэрхэн халдвар авсан эсвэл бусдад халдвар тараасан байж болох талаар мэдээлэл өгнө гэсэн үг юм.

Таны ярих зүйлийг нууцлах бөгөөд таны хэлсэн хүмүүс таныг хэн болохыг мэдэхгүй.

Халдвар хамгааллын хуудсын тухай

Халдвар хамгааллын хуудсыг Халдвар хамгааллын эмч нарын нийгэмлэг боловсруулсан бөгөөд хуудас үндэсний хэмжээнд хамаатай.